



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

# МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2023 оны 06 дугаар  
сарын 08 өдөр

Дугаар 123/2023

Улаанбаатар-16100  
Утас: 70001150  
Факс: 70007636

<b>Объектын нэр:</b>	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто замын зураг төсөл		
<b>Объектын байршил:</b>	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,		
<b>Хүчин чадал:</b>	0.863 км, 0.089 км, 18.6 у/м		
<b>Захиалагч:</b>	Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл хэрэгжүүлэх нэгж		
<b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b>	Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт		
<b>Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,</b>	"Ихэр мөнх" ХХК		
<b>Регистрийн дугаар:</b>	5914337		
<b>Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:</b>	2025.03.18		
<b>Зураг төсөл боловсруулах үндэслэл:</b>			
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	-		
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Нийслэлийн замын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталсан авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавар, № ЗДЧД2022/04,		
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар болон "Ихэр мөнх" ХХК-ийн хооронд 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан авто зам, гүүрний зураг төсөл боловсруулах ажлын гэрээ, № ЧДХААА ДТХ-ЗҮ-22/03 Зургийн гэрээний үнэ: 154 623 888 төгрөг,		
<b>Техникийн нөхцөл:</b>			
Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Шинэ холболт	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№ 15/01584/23 2023.04.25	1 жил
<b>Зөвшилцсөн байгууллага:</b>			
Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга			П.Баянбаатар
Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны Засаг дарга			В.Хүрэлбаатар
Нийслэлийн замын хөгжлийн газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга			Г.Баттогтох
Нийслэлийн замын хөгжлийн газрын Замын хөдөлгөөн төлөвлөлтийн хэлтсийн дарга			Б.Одбаяр
Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга			Г.Батзориг
Геодези, усны барилга байгууламжийн газрын ерөнхий инженер			С.Батсайхан
"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер			Т.Мөнхболд
<b>Зураг төслийн бүрэлдэхүүн:</b>			
Зургийн бүрдэл:	Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:	
Авто замын зураг төсөл	"Ихэр мөнх" ХХК	Р.Болормаа	
Тайлбар бичиг			
Техникийн шаардлага			

Авто замын төсөв		Б.Минжбадам
Геодезийн тайлан	"Эйр сурвей" ХХК	-
Инженер-геологийн тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2023.04.03-ны өдөр магадлал хийсэн байна./	"Лэнд тест" ХХК Архив № 23/103	-
Гэрэлтүүлгийн зураг төсөл	"Паэур куалити" ХХК	Ч.Наранцэцэг
Гэрэлтүүлгийн төсөв		Г.Гантуяа

**Зураг төслийн бүрэлдэхүүн:**

Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт

**Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:**

**Авто замын ангилал:** Нутаг дэвсгэрийн зам

**Төрөл 1:**

Зорчих хэсгийн өргөн 6.0м, ногоон байгууламжийн өргөн 1x0.4м, явган хүний замын өргөн 1x2.0м, хөвөөний өргөн 2x0.5м,

**Төрөл 2:**

Зорчих хэсгийн өргөн 6.0м, хөвөөний өргөн 2x0.5м байхаар төлөвлөсөн байна.

**Авто замын хучилтын хийц:**

**Төрөл 1:**

Өнгө асфальтбетон хучилт	30мм
Суурь асфальтбетон хучилт	40мм
Буталсан чулуун суурь үе	200мм
Хөлдөлтөөс хамгаалах үе	300мм

**Төрөл 2:**

Буталсан чулуун суурь үе	200мм
Хөлдөлтөөс хамгаалах үе	300мм

**Явган хүний замын хучилтын хийц:**

Асфальтбетон хучилт	50мм
Буталсан чулуун суурь	200мм

**Төмөрбетон хоолой:**

ПК0+107.68 байршилд Ø1.0м хэмжээтэй төмөрбетон дугуй хоолой байхаар төлөвлөсөн байна.

**Төмөрбетон гүүр:**

Гүүрийн зорчих хэсгийн өргөн	8.0м
Гүүрийн нийт өргөн	12.0м
Гүүрийн сонгосон урт	L = 18.6 у/м
Алгаслын хийц	Хавтант дам нуруу
Явган хүний зам	2x1.2м

**Төмөрбетон гүүрийн хучилтын хийц:**

Асфальтбетон хучилт	65мм
Хавтан алгаслал	

**Авто замын гэрэлтүүлэг:**

Алсын удирдлагатай гадна гэрэлтүүлгийн удирдах самбар 1 ком, нэг толгойтой 9м-н өндөр гэрэлтүүлгийн шон 38ш, 120вт-ын гэрэлтүүлэгч 38ш, 0.4-10кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам шилжүүлэн зөөхөөр төлөвлөсөн байна.

Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:

Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд:

**Зураг төсөлд:**

Авто замын зураг төсөлд /2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дүгнэлт/

Гэрэлтүүлгийн зураг төсөлд /2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дүгнэлт/

**Төсөвт:**

Авто замын төсөвт /2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дүгнэлт/

Гэрэлтүүлгийн төсөвт /2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн дүгнэлт/

Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно.

Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого,

Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд:

<p>хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт</p>	<p>-ЗЗБНБД 22-004 -2016 “Авто зам төсөллөх”          -БНБД 30-01-04 “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм”          -БНБД 32-01-04 “Хот суурины гудамж, зам төлөвлөлт”          -БНБД 32-02-12 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх”          -БНБД 81-25-07 “Авто замын барилгын төсвийн жишиг норм”          -БНБД 81-28-07 “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм”          -ЗЗБНБД 81-013-2019 “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм”          -БНБД 81-95-12*/2020 “Барилгын төсөв зохиох дүрэм”          -БД 43-101-03 “Цахилгаан байгууламжийн дүрэм”          -MNS 6846:2020 “Хот тосгон бусад суурин авто зам, гудамж талбайн гэрэлтүүлэг. Техникийн ерөнхий шаардлага”</p>
<p>Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт</p>	<p>Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Үүнд:          Авто замын барилгын ажлын төсөв <b>2 639 809 927</b> төгрөг, Гэрэлтүүлэг, цахилгаан дамжуулах шугам шилжүүлэх ажлын төсөв <b>213 986 605</b> төгрөг          Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянаж, дүгнэв.</p>

**“Авто замын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто замын зураг төслийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр замын барилгын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг төслийн баримт бичигт “Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 7 хуудас)

“ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ  
 БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
 БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Х.ПҮРЭВЖАРГАЛ

Д.БАЗАРСАД

Э.ЭНХТӨГС

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 17 ДУГААР ХОРОО, 103 ДУГААР ЦЭЦЭРЛЭГЭЭС ЧИНГЭЛТЭЙН ГУДАМЖ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ЗУРГИЙН ДУГААР: 23/06

2023 оны 05-р сарын 01-ний өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	Чингэлтэй дүүрэг, 17-р хороо, 103-р цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто замын зураг төсөл
2	Объектын байршил, хүчин чадал:	УБ хотын ЧД-ийн 17-р хорооны нутаг дэвсгэрт хамрагдана.
3	Зураг төслийн байгууллага:	"ИХЭР МӨНХ" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Газар зохион байгуулалтын холбогдох мэргэжилтэнтэй зөвшилцөх;
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Замын далангийн гол талын хажуу налууг бэхлэх; Хажуу налуун бэхэлгээг нэг маягийн хөндлөн огтлолд тусгах;
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Замын гэрэлтүүлэг төсөллөх;
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Замын төгсгөл хэсгийн дагуу налууг ЗЗБНД-д зааснаар 8%-иас ихгүй төсөллөх;
/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/		
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Гүүрийн хоёр талын татам хэсгийн далан болон хажуу налуун бэхэлгээг төсөллөлтөнд тавигддаг шаардлагын дагуу төсөллөх;
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Явган хүний замын өргөнийг норм дүрэм зааснаас багагүй хэмжээгээр төсөллөх;
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Явган хүний замыг асфальтбетон хучилттай төсөллөх боломжийг судлах; Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг тэмдэглэгээр хийх боломжийг тусгах;
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Засваруудыг хийн ажлын тоо хэмжээг хянуулах;
Дүгнэлт бичсэн: Засвар сайжруулалтуудыг хийж дахин хянуулах Эксперт № _____ /овог, нэр / 2023 оны 05-р сарын 01-ний өдөр		



Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 17 ДУГААР ХОРОО, 103 ДУГААР ЦЭЦЭРЛЭГЭЭС ЧИНГЭЛТЭЙН ГУДАМЖ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ, ЗУРГИЙН ДУГААР: 23/06

2023 оны 05-р сарын 01-ний өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр:	Чингэлтэй дүүрэг, 17-р хороо, 103-р цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто замын зураг төсөл
2	Объектын байршил, хүчин чадал:	УБ хотын ЧД-ийн 17-р хорооны нутаг дэвсгэрт хамрагдана.
3	Зураг төслийн байгууллага:	"ИХЭР МӨНХ" ХХК

Д/Д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Газар зохион байгуулалтын холбогдох мэргэжилтэнтэй зөвшилцөх;	Авто замын трассыг газар дээр нь ЧДЗДТГ, НЭХГ, ГУББГ болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны холбогдох мэргэжилтнүүдтэй зөвшилцсөн болно.
2	Замын далангийн гол талын хажуу налууг бэхлэх; Хажуу налуун бэхэлгээг нэг маягийн хөндлөн огтлолд тусгах;	Авто замын үерийн усны шуудуутай хэсэгт хажуу налууг тулц ханатай байхаар төсөллөсөн ба нэг маягийн хөндлөн огтлолд хийцлэл болон хийгдэх хэсгийг тусгаж өгсөн болно.
3	Замын гэрэлтүүлэг төсөллөх;	Авто замын трасст орсон цахилгаан дамжуулах шугам болон авто замын гэрэлтүүлэгийн зураг төсөлийг Пауэр Куалити ХХК хийж гүйцэтгэж байна.
4	Гүүрийн хоёр талын татам хэсгийн далан болон хажуу налуун бэхэлгээг төсөллөлтөнд тавигддаг шаардлагын дагуу төсөллөх;	Гүүрийн хоёр талын татам хэсгийн далан болон хажуу налуун бэхэлгээг төсөллөлтөнд тавигддаг шаардлагын дагуу төсөллөв.
5	Явган хүний замын өргөнийг норм дүрэм зааснаас багагүй хэмжээгээр төсөллөх;	Явган хүний замыг авто замын зөвхөн нэг талд нь 2м өргөнтэйгээр төлөвлөв.
6	Явган хүний замыг асфальтбетон хучилттай төсөллөх боломжийг судлах; Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч замыг тэмдэглэгээр хийх боломжийг тусгах;	Явган хүний авто замыг асфальтбетон хучилттай, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөчийг замын тэмдэглэгээний машинаар хийхээр төлөвлөв.
7	Засваруудыг хийн ажлын тоо хэмжээг хянуулах;	Алдаа зөрчлийг засаж хүргүүлэв.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № *23/06/23* /овог, нэр/

..... он .... сар ..... өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /овог, нэр/

..... он .... сар ..... өдөр



**Зураг төслийн баримт бичгийн  
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1**

**ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО**

Цахилгаан, гэрэлтүүлгийн зураг төсөл

2023 оны 05 сарын 31 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто зам
2	Объектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо баг/хороо; 1,1 км
3	Зураг төслийн байгууллага	"Ихэр мөнх" ХХК
<b>3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/</b>		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо баг/хороо; 1,1 км ГГ-7 хуудас, "Пазур Куалити" ХХК-ийн Шифр: RQ23-12, ГГ-07, ГГ-11 хуудасны бүрдэлтэй. Инженер Ж.Эрдэнэбат, Гүйцэтгэсэн Э.Төгөлдөр 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх, Авто замын гэрэлтүүлэг, авто замд орсон шугамын шилжүүлэлт тусгагдсан.  "УБЦТС" ТӨХК-ийн 2023.04.25-ны өдрийн №15/01584/23 тоот техникийн нөхцөл. "НГЗБА"-ны дарга Г.Батзориг "УБЦТС" ТӨХК-ийн Ерөнхий инженер Т.Мөнхбаттай зөвшөөрөлцсөн
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Иш татсан баримт бичгийн жагсаалт Цахилгаан байгууламжийн дүрэм /БД43-101-03/. Барилга байгууламжийн аянга хамгаалалтын зураг төсөл зохиох заавар /БД43-103-08/ Хот тосгон сум,суурийн газрын гудамж зам талбайн гэрэлтүүлэг төлөвлөх заавар /БД30-102-11/ Авто зам төлөвлөх /БНБД ...../
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Авто замын трассын дагуу төлөвлөгдсөн.
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Тулгуурын газардуулга хийгдсэн
<i>/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/</i>		
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Авто замын трассын дагуу, техникийн нөхцлийн дагуу төлөвлөгдсөн.
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	-
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Цахилгаан сүлжээний хүчдэл 380/220В байна. Шилжүүлэлт хийгдсэн шугамын хүчдэл 0.4 кВ-ын ЦДАШ байна. Гэрэлтүүлгийн нийт урт 1.235 км байна. Pт=3.9 кВт, It=10.26А байна.
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	хамаарахгүй
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Техникийн нөхцлийн дагуу төлөвлөгдөн холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшөөрөлцсөн байна.
Дүгнэлт бичсэн:		
Эксперт № 61-04 /Ч.Наранцэцэг/ ..... 2023 оны 05 сарын 31 өдөр		

**Зураг төслийн баримт бичгийн  
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1  
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР /Төсвийн тооцоо/**

Д/д	Утга	Тайлбар
2	Объектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо баг/хороо; 1,1 км
2	Объектын нэр, шифр	Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто зам, 23/06
3	Объектын бүрдлийн хэсгийн нэр, хуудасны тоо, гүйцэтгэсэн ААН байгууллага	Цахилгаан, гэрэлтүүлгийн төсөв, "Ихэр мөнх" ХХК
4	Төсвийн тооцооны программ, төсвийн тооцоог хийсэн байгууллагын нэр, гүйцэтгэсэн инженер	Estimator-pro программ. Мэргэшсэн төсөвчин Ц.Батзаяа Магадлалд ирүүлсэн төсөв 213,986,605 төгрөг
5	Зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын тоо хэмжээг үнэн зөв тодорхойлсон байдал	Ажлын тоо хэмжээг зөв тооцсон байна.
6	Төсвийн тооцоонд ашигласан норм, норматив, үнэ үнэлгээ	Төсвийн тооцоонд БНБД 81 төсвийн суурь нормууд, БХБС-ын 2020 оны 02-р сарын 05-ны өдрийн 30 тоот тушаалаар батлагдсан Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12*/2020, Цалингийн зардалд БХБС-ын 217-р тушаал, тээврийн зардалд ЗТХС-ын 2019.12.13-ны өдрийн 371-р тушаал, механизмын зардалд ЗТБХБС-ын 2012.01.13-ны 18-р тушаалыг ашиглажээ.
7	Төсвийн тооцооны арга, аргачлалын оновчтой байдал, төслөөр тодорхойлсон нөөцийг оновчтой ашигласан байдал	
8	Төсвийн тооцоо, түүний хэлбэржүүлэлтэд зайлшгүй оруулах шаардлагатай засвар, өөрчлөлт	Өөрчлөлттэй
	Дүгнэлтийн товч утга	
1	Төвийн тооцоо нь дагаж мөрдөж буй норм, дүрэм, стандартын дагуу, оновчто зохиогдсон эсэх	Төсвийн тооцоонд дараах өөрчлөлтийг оруулах
Дүгнэлт бичсэн:		
Эксперт № 62-01 /Г.Гантуяа/		2023 оны 06 сарын 02-ны өдөр

**Зураг төслийн баримт бичгийн  
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2**

**ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР**

Цахилгаан, гэрэлтүүлгийн төсөв

2023 оны 06 сарын 02 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо, 103 дугаар цэцэрлэгээс Чингэлтэйн гудамж хүртэлх авто зам
2	Объектын байршил, хүчин чадал	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 17 дугаар хороо баг/хороо; 1,1 км
3	Зураг төслийн байгууллага	"Ихэр мөнх" ХХК

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Гэрэлтүүлэгч 120Вт үнэ судалж тусгах	Филлипс ХХК-ийн 70288280 утсаар холбогдож гэрэлтүүлгийн үнэ тооцсон
2	Гэрэлтүүлгийн шон 9м-жин буруу байгааг засах	Уай Эл Эм ХХК-ийн 99098040 утсаар холбогдон тулгуурын жин үнэ асууж тооцсон.
3	Дээрх тайлбарыг үндэслэн төсөвт өртгийг 213,986,605 төгрөгөөр баталгаажуулав.	Уай Эл Эм ХХК-ийн 99098040 утсаар холбогдон тулгуурын жин үнэ асууж тооцсон.
Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 62-01 2023 он 06 сар 01 өдөр		..... /Г.Гантуяа/
Биелэлтийн тайлбар бичсэн 2023 он 06 сар 02 өдөр		..... /Ц.Батзаяа/